

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ... –ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:**

1/3 дугаар зүйлийн 3.2.1, 3.2.2, 3.2.3. дахь заалт:

3.2.1. Комиссын дэргэд хүний эрх, эрх чөлөөний чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, хүний эрхийн хараат бус шинжээчдийн бүрэлдэхүүн бүхий хүний эрхийн олон нийтийн орон тооны бус зөвлөл ажиллана.

3.2.2. Хүний эрхийн олон нийтийн зөвлөл нь Комиссын үйл ажиллагаанд санал, зөвлөмжийг өгөх, бие даасан хараат бус үнэлгээ, дүгнэлт өгөх чиг үүрэгтэй байна.

3.2.3. Хүний эрхийн олон нийтийн зөвлөлийг аймаг, хотын хэмжээнд байгуулж болно. Аймаг, хотын хэмжээнд байгуулах үйл ажиллагааг Хүний эрхийн Үндэсний Комисс хариуцан зохион байгуулна.

2/14 дүгээр зүйлийн 14.1.1-14.1.4. дахь заалт:

“14.1.1. Комиссыг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх, ажиллын албаны бүтэц зохион байгуулалтыг батлах, удирдлагыг томилох; “

“14.1.2. Комиссын бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудад дүгнэлт, зөвлөмж, саналыг хугацаа заасан шаардлага хүргүүлж, тайлбар авах; “

“14.1.3. Комиссын болон гишүүдийн үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;”

“14.1.4. Комиссын үйл ажиллагааны тайланг тогтмол хугацаанд УИХ-д танилцуулах, илтгэл, мэдээлэл, судалгаа шинжилгээгээр хангах;”

3/16 дугаар зүйлийн 16.1.9,-16.1.12.,16.3. дахь заалт:

16.1.9. Хохирогчтой ганцаарчлан уулзах,гэмтэл хохирлыг баримтжуулах, энэ зорилгоор үзлэгийн өрөө, уулзалтын байр гаргуулж авах.

16.1.10. Баримтжуулалт хийхэд шаардлагатай техник хэрэгсэл, мэргэжлийн хүмүүсийг үзлэгт хамт авч явах, тэдгээрийг өөрийн үйл ажиллагаа явуулж буй бүх газарт саадгүй нэвтрүүлж оруулах.

16.1.11. Хохирогчтой ямар нэгэн гэрчгүй уулзах

16.1.12. Аливаа төрлийн дарамт, эрүүдэн шүүхийн ямарваа нэг хэлбэр, тарчлаан зовоох зөрчил гарч байгаа бол хоригдож буй өрөө, байрыг даруй солиулж, шаардлагатай бол батлан даалтад гаргуулах

16.3. Хүний эрхийг ноцтойгоор зөрчсөн тохиолдолд холбогдох этгээдийг батлан даалтанд гаргах асуудлыг хүний эрхийн үндэсний комиссын гишүүн комиссын хуралдаанд танилцуулж комиссын даргын гарын үсэг бүхий албан тоотыг холбогдох хууль, цагдаа, шүүхийн байгууллагад явуулна. Холбогдох хууль, цагдаа, шүүхийн байгууллага уг албан тоотыг хүлээн авсан даруй уг шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

4/18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсэг:

18.6.Эрүүдэн шүүхийн эсрэг олон улсын конвенци, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон зүйл, заалтыг ноцтойгоор зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох албан тушаалтанд онцгой шаардлага хүргүүлэх, холбогдох албан тушаалтныг томилсон дээд шатны байгууллага, албан тушаалтаныг уг албан тушаалаас нь нэн даруй чөлөөлөх саналаа тавина.”

**2 дугаар зүйл. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:**

1/3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг:

“3.1.Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээ, конвенцид заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрх, эрх чөлөөг сахин хамгаалах, дэмжих зорилго бүхий бие даасан, хараат бус байгууллага мөн.”

2/3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг:

“3.4.Аливаа байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгж, хувь хүн, комисс, түүний гишүүний үйл ажиллагаанд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно. Комиссын гишүүн нөлөөллийн мэдүүлгийг шаардлагатай тохиолдолд бөглөнө.:

3/4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг:

“4.1.Комиссын гишүүнд нэр дэвшигч нь хууль зүй, эдийн засаг, нийгэм, улс төрийн өндөр мэдлэгтэй, хүний эрх, эрх чөлөөний талаар зохих мэдлэг, туршлагатай Монгол Улсын гучин таван насанд хүрсэн иргэн байна.”

4/5 дугаар зүйлийн 5.1.,5.2 дахь хэсэг:

“5.1. Комиссын гишүүнд нэр дэвшигчийн нэрийг Ерөхийлөгч болон Улсын Их Хурлын хүний эрхийн дэд хорооны саналыг үндэслэн Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын Хороо УИХ-д өргөн мэдүүлнэ.

“5.2. Улсын Их Хурал нэр дэвшигчийг Комиссын гишүүнд томилохоос татгалзсан бол арван дөрвөн хоногийн дотор энэ хуулийн 5.1-д заасан журамын дагуу өөр хүний нэрийг дэвшүүлнэ.”

5/13 дугаар зүйлийн 13.1.1., 13.1.2., 13.1.3 дахь заалт:

“13.1.1. Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар санал гаргах, шаардлага тавих, даалгавар өгч, биелэлтийг хангуулах;

“13.1.2.Хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчим, үзэл санаанд нийцэж буй эсэх талаар бие даасан, хараат бус дүгнэлт, зөвлөмж, санал гаргах, нийцүүлэх талаар шаардлага тавих;”

“13.1.3.Олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийн биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлд санал, зөвлөмж өгөх, байр суурь, санал дүгнэлт зөрсөн нөхцөлд тухайн асуудлаар Улсын Их Хуралд дүгнэлт, саналаа ирүүлж шийдвэрлүүлэх;”

6/15 дугаар зүйлийн 15.1.1.,15.1.4. дэх заалт:

“15.1.1.Гомдлыг хүлээн авч, хянан үзэж, санал, дүгнэлт зөвлөмжөө комиссын хуралдаанаар хэлэлцүүлж, хамгаалах; “

“15.1.4.Гомдол гаргагчид зөрчигдсэн эрхээ сэргээлгэх талаар ямар эрх, үүрэгтэй болохыг тайлбарлах, зөвлөгөө өгөх, холбогдох байгууллага,албан тушаалтанд бичгээр мэдэгдэх;”

7/17 дугаар зүйл, 17.1.2.,17.1.3. дахь заалт:

“17 дугаар зүйл. Гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон Комиссын гишүүний бүрэн эрх.”

“17.1.2.хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзсэн албан тушаалтанд захиргааны хариуцлага хүлээлгэх саналаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих, шаардлага хүргүүлэх;”

“17.1.3. хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, зөрчих нөхцөл бүрдүүлсэн үйл ажиллагаагаа зогсоохыг байгууллага, албан тушаалтнаас шаардах, албан даалгавар хүргүүлэх;”

8/18 дугаар зүйлийн 18.2. дахь заалт:

“18.2. Комиссын гишүүн нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа талаархи мэдээллийг үндэслэн өөрийн санаачлагаар, эсхүл аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, албан тушаалтны хүсэлтээр шалгалт хийж болно.

9/19 дүгээр зүйл, 19.1.,19.5.,19.6. дахь хэсэг:

“19 дүгээр зүйл. Комиссын гишүүний шаардлага, албан даалгавар зөвлөмж.”

“19.1. Комиссын гишүүн нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлага, албан даалгавар, зөвлөмж гаргана.”

“19.5. Комиссын гишүүний шаардлага, албан даалгавар, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авахаас татгалзсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны талаар хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж болно.”

“19.6. Комиссын гишүүн нь гаргасан шаардлага, албан даалгавар, зөвлөмжөө хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх, мэдээлэх эрхтэй.”

10/26 дугаар зүйлийн 26.1. дахь хэсэг:

“26.1. Энэ хуулийн 3.4,19.4,23.4-ийг зөрчсөн иргэнийг 200.000-1 сая, албан тушаалтанд 1 сая-5 сая, аж ахуйн нэгж байгууллагыг 5 сая-20 сая төгрөгөөр торгоно.”

**3 дугаар зүйл. Энэ хуулийг 2014 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

**Гарын үсэг**